



НИЙТ МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ
ЭТГЭЭДЭД

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2023.04.20 № 9/1602
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага буюу ФАТФ-аас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (МУТС, УОХЗДС)-тэй тэмцэх тогтолцооны дутагдалтай улсуудын жагсаалт буюу “хар”, “саарал” жагсаалтын талаарх мэдээллийг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хүргүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тусгасан.

Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо нь зохицуулалтын нийт мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд үүсэж болох аливаа эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах үүднээс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны дутагдалтай улсуудын шинэчлэгдсэн жагсаалтыг хавсралтаар хүргүүлж байна.

Тус Хорооны зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээд Та энэхүү зөвлөмжийг өөрийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлэхийг зөвлөө.

Хавсралт: 1 хуудастай.


ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДОЛГОРСҮРЭН

1518003080

Санхүүгийн зохицуулах хорооны
2023 оны 11-р сарын 22-ны өдрийн
9/1602 дугаартай албан бичгийн хэвсрэлт



МУТС, ҮОХЗДС-тэй тэмцэх тогтолцооны дутагдалтай улсууд

1. МУТС, ҮОХЗДС-тэй тэмцэх тогтолцооны стратегийн дутагдлыг тодорхой хугацаанд багтаан арилгах үүрэг хүлээн, ФАТФ-тай идэвхтэй хамтран ажиллаж байгаа улс орнуудыг саарал жагсаалт буюу өргөтгөсөн хяналтад оруулдаг. ФАТФ-ын саарал жагсаалтад 2023 оны 02 дугаар сарын байдлаар дараах улс орнууд багтсан байна. Үүнд:
 - Бүгд Найрамдах Албани Улс
 - Барбадос
 - Буркина Фасо
 - Кеймэнн арлууд
 - Бүгд Найрамдах Конго Улс (БНКУ)
 - Гибралтар
 - Хаити
 - Ямайка
 - Йорданы Хашемын Хаант Улс
 - Мали
 - Бүгд Найрамдах Мозамбик Улс
 - Нигер
 - Бүгд Найрамдах Панам Улс
 - Бүгд Найрамдах Филиппин Улс
 - Бүгд Найрамдах Сенегал Улс
 - Өмнөд Африк
 - Өмнөд Судан
 - Арабын Бүгд Найрамдах Сири Улс
 - Бүгд Найрамдах Нэгдсэн Танзани Улс
 - Бүгд Найрамдах Турк Улс
 - Уганда
 - Арабын Нэгдсэн Эмират Улс
 - Бүгд Найрамдах Йемен Улс
2. МУТС, ҮОХЗДС-тэй тэмцэх тогтолцоо нь стратегийн томоохон дутагдалтай, өндөр эрсдэлтэй улс орнуудыг хар жагсаалтад оруулдаг. ФАТФ-аас өөрийн нийт гишүүд болон бүх улс орнуудад хандан өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон улсуудтай холбоотойгоор харилцагчийг таньж мэдэх өргөтгөсөн хяналт тавихыг уриалж, ноцтой тохиолдолд тухайн улсаас үүсэж буй МУТС, ҮОХЗДС эрсдэлээ олон улсын санхүүгийн системийг хамгаалахын тулд хариу арга хэмжээ авахыг уриалдаг. Дараах улс орнууд ФАТФ-ын хар жагсаалтад багтсан байна. Үүнд:
 - Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (БНАСАУ)
 - Иран
 - Мьянмар